



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 10 сарын 19 өдөр

Дугаар A/505

Арвайхээр


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн "Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих жил" болгон зарлах тухай 03/06 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн "Зорилтот жилийн төлөвлөгөө батлах тухай" А/31 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих жил"-ийн хүрээнд малчид, газар тариалан эрхлэгчдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд нэгдсэн журмаар хамруулах ажлын удирдамжийг нэгдүгээр, шаардагдах урвалж, оношлуур болон шатахууны зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хавсралтад тусгагдсан 9,484,897 (есөн сая дөрвөн зуун наян дөрвөн мянга найман зуун ерэн долоо) төгрөгийг орон нутгийн төсөвт батлагдсан зорилтот жилийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101068

Аймгийн Засаг даргын 2021 оны 10
дугаар сарын 19-ны өдрийн 505
дугаар захирамжийн нэгдүгээр
хавсралт




“ХЭНИЙГ Ч ОРХИГДУУЛАХГҮЙ БАЙХ” ЯВУУЛЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ АЖЛЫН УДИРДАМЖ

Үндэслэл: Хүн амын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, халдварт ба халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Монгол улсын Засгийн газар болон Эрүүл мэндийн яамнаас хөтөлбөр стратеги, төлөвлөгөөнүүдийг гаргаж, салбар дундын оролцоотойгоор хэрэгжүүлж байгаа билээ. Тухайлбал “Элэг бүтэн Монгол”, “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” гэх мэт томоохон үндэсний хөтөлбөр, Монгол улсын Ерөнхий сайдын “Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 2020-2022”, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмж “Бүх нийтийн эрүүл мэндийн хамралт”, “Хэнийг ч орхигдуулахгүй байх” зарчим, Эрүүл мэндийн сайдын 2016 оны “Эрүүл мэндийн үйлчилгээг явуулын хэлбэрээр үзүүлэх” тухай А/147, 2018 оны “Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт хамруулах тухай” А/420, 2021 оны “Хавдрын эсрэг төлөвлөгөө батлах тухай” А/360, “Эрүүл чийрэг эр хүн арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” А/559, аймгийн Засаг даргын 2021 оны “Төлөвлөгөө батлах тухай” А/31 дүгээр захирамж зэрэг бодлогын баримт бичгүүд хэрэгжиж байна. Дээрх хөтөлбөр, стратеги, төлөвлөгөөнүүдийг салбар дундын оролцоотойгоор хэрэгжүүлсний үр дүнд аймгийн хүн амын дундаж наслалт 71.37, улсын дунджаас 0.9 хувиар дээгүүр түвшинд хүрсэн хэдий ч /эрэгтэй 68.9, эмэгтэй 74.08/ эрэгтэй эмэгтэй хүний дундаж насны зөрүү 5.1, эх, хүүхдийн эндэгдэл, халдварт бус өвчний өвчлөл тууштай буурахгүй байна.

Манай аймгийн суурин хүн ам 115737 байгаагийн 82846 буюу 71.6 хувь нь суманд амьдарч байгаа бөгөөд 2020 онд нийт 56326 халдварт бус өвчин бүртгэгдсэний 17038 буюу 30.2 хувь нь сумдад /Хархорин, Баруунбаян-Улаан, Төгрөг, Хайрхандулаан, Уянга сумдад 1201-5740 тохиолдол буюу 10000 хүн амд 2.1-10.2/ хувийг эзэлж өвчлөлөөр тэргүүлж байна. Нийт халдварт бус өвчлөлийн 22644 буюу 40.2 хувь нь 20-49 насанд бүртгэгдсэн ба үүнээс хоол боловсруулах, бөөр, шээсний зам, зүрх судасны өвчлөл тэргүүлж, өвчлөгсдийн дийлэнх хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Тухайн насанд 89 нас баралт бүртгэгдсэний 67 буюу 75.2 хувийг эрэгтэйчүүдийн нас баралт эзэлж байна. Эдгээр статистик үзүүлэлтээс харахад эрэгтэйчүүдийн үзлэгт хамрагдалт хангалтгүй, эмэгтэйчүүдийн дунд бөөр, шээсний замын эмгэг их байна.

Эрүүл мэндийн газраас жил бүр “Эх, хүүхдийн явуулын үзлэг”-ийг зохион байгуулж ирсэн бөгөөд энэ оны хувьд нарийн мэргэжлийн эмчийн үзлэгийг 2021 оныг аймгаас “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан, Хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтран, малчин, тариаланчдын үзлэгтэй хамтатган зохион байгуулж, урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд зорилтот насны иргэдийг хамруулах шаардлагатай байгаа нь дээрх тоо баримтаас тодорхой харагдаж байна.



Зорилго: Аймаг, сумын төвөөс алслагдсан хөдөө орон нутаг, багт амьдарч байгаа үзлэг шинжилгээнээс хоцрогдох эрсдэл бүхий нөхөн үржихүйн насны эрэгтэй, эмэгтэй, эрсдэл бүхий жирэмсэн эх, суурь эмгэгтэй хүүхдийг анхан шатны болон нарийн мэргэжлийн эмчийн үзлэг шинжилгээнд хамруулж, өвчлөлийг илрүүлэн, хяналтад авч, эмчлэн эрүүлжүүлэх замаар хүндрэл, эндэгдлийг бууруулах мэдээлэл зөвлөгөөгөөр хангах, иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийн төвүүдийн тусламж үйлчилгээнд дэмжлэгт хяналт хийж, зөвлөн туслахад оршино.

1.Зорилт

1.1.Зорилтот насны иргэдийг нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, шинжилгээнд хамруулж, өвчлөлийг илрүүлэн, хяналтад авч, эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээ авах

1.2.Үзлэг, шинжилгээнд хамрагдагсад, ар гэрийнхэнд халдварт ба халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэгт хамрагдахын ач холбогдол, нөхөн үржихүйн эрүүл мэнд, коронавируст халдвараас өөрийгөө болон гэр бүлээ хамгаалах мэдээлэл сургалт, сурталчилгаанд хамруулах

1.3.Сумдын эмнэлэг, эрүүл мэндийн төвийн нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээнд дэмжлэгт хяналт хийж, зөвлөн туслах

2.Зохион байгуулагч байгууллага

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн газар, Монголын гэр бүлийн сайн сайхны нийгэмлэгийн салбар зөвлөл хамтран зохион байгуулна.

Хамтран ажиллах байгууллага: Сумдын Засаг даргын Тамгын газар, эмнэлэг, эрүүл мэндийн төвүүд хамтарч ажиллана.

3.Хамрах хүрээ: Сумдын малчин өрхийн 30-аас доошгүй хувь болон удирдамжид тусгагдсан эрсдэлт бүлэгт хамаарах хүн амын 60-аас доошгүй хувийг тус тус үзлэг, шинжилгээнд хамруулна.

4.Үзлэг, шинжилгээний ажлын зохион байгуулалт:

- Үзлэг, шинжилгээний удирдамж, сумдад ажиллах графикийг сумдын эмнэлэг, эрүүл мэндийн төвд урьдчилан хүргүүлэх

- Нарийн мэргэжлийн үзлэг, шинжилгээнд хамрагдах /алслагдсан багийн үзлэг шинжилгээнээс хоцордог, эрсдэл бүхий иргэд, ялангуяа 20-49 насны иргэд, жирэмсэн эх, нөхөн үржихүйн эрэгтэйчүүд, эмзэг бүлгийн эмэгтэйчүүд, суурь эмгэгтэй бага насны хүүхэд/ зэрэг зорилтот насны иргэдийн судалгааг нэр, нас, хүйс, эрсдэл, хаяг байршил, үзлэгийн төрлөөр нь 10 дугаар сарын 18-ны дотор гаргасан байх.

- Судалгаанд хамрагдсан иргэдийг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулах зарыг хүн бүрд урьдчилан хүргэж, графикт хугацаанд үзлэг, шинжилгээнд бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах

5.Үзлэг зохион байгуулах хугацаа:



- Нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, шинжилгээ, дэмжлэгт хяналт, зөвлөн туслах баг нь 2 ээлжээр сумдад ажиллана.

- 1-р ээлжийн баг 10 дугаар сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл 12 өдөр хангай, зүүн бүсийн сумдад ажиллана.

- 2-р ээлжийн баг 11 дүгээр сарын 3-ны өдрөөс 11 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл говь, баруун бүсийн сумдад ажиллана.

6.Сум, өрхийн эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

а.Нөхөн үржихүйн насны эрэгтэй, эмэгтэйчүүд, цэргийн насны залуучууд, 0-5 насны хүүхдийн бүртгэл, шилжилт хөдөлгөөний мэдээлэл, /эмзэг бүлгийн, түр оршин суугч, хөдөлгөөнт хүн ам, суурь эмгэгтэй хүүхэд/ судалгааг тодорхой гаргасан байна. /Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн судалгааг google drive программд бүрэн шивж оруулан, дүгнэлт хийсэн байх/

б.Жирэмсний нэрийн хяналтын программыг бүрэн хэрэгжүүлж, товллын үзлэгт бүрэн хамруулан, эрсдэлтэй жирэмснийг илрүүлж, эмчлэн эрүүлжүүлэлтэд дүгнэлт, судалгаа хийсэн байх

в.Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд, ялангуяа эмзэг бүлгийн иргэдийн жирэмслэхээс сэргийлэх аргад хамрагдалт, жирэмслэхээс сэргийлэх эм, хэрэгслийн орлого, зарцуулалтын бүртгэл, тайланг Эрүүл мэндийн Сайдын 2019 оны А/563 дугаар тушаалын дагуу гаргасан байх

г.Үзлэгт хамруулахаар сонгосон зорилтот насны иргэдийн судалгааг нэрсээр нь гаргаж, үзлэгт ирүүлсэн байна.

д.Үзлэгт хамрагдах иргэдэд хавсралтад тусгагдсан шинжилгээнүүдийг хийх бэлтгэлийг хангасан байна. /ХДХВ/ДОХ, тэмбүү, ЭКГ, ЭХО, гепатитийн В, С вирус илрүүлэх болон хөх, умайн хүзүү, чихрийн шижин, артерийн гипертензийн эрт илрүүлэг гэх мэт/

е.Нөхөн үржихүйн насны эрэгтэй, эмэгтэйчүүдийн хепатийн В, С вирусийн илрүүлэг болон идэвхжил тоолох шинжилгээ, вирусийн эсрэг эмчилгээнд хамрагдалт, эрүүлжүүлэлтэд дүгнэлт хийсэн байх

ж.Үзлэг, шинжилгээг цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан, холбогдох, заавар, журмын дагуу халдвар хамгааллын дэглэм хангасан орчинд зохион байгуулах бэлтгэлийг хангасан байх

з.Сум, өрхийн эмнэлэг, эрүүл мэндийн төвүүд нь үзлэгийн тоон болон бичмэл тайланг загвар маягтын дагуу гаргаж, үзлэг хийгдсэнээс хойш 5 хоногийн дотор Эрүүл мэндийн газрын НЭМХ-ийн ахлах мэргэжилтэн С.Дуламсүрэнгийн dulamsuren.sukh@gmail.com, _____ЭТХ-ийн мэргэжилтэн Б.Ариунзаяатын ariunaab.0408@gmail.com цахим хаягаар тус тус ирүүлэх

7. Эрүүл мэндийн газар, БОЭТ-ийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэгийн багийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

а.Нарийн мэргэжлийн үзлэг, шинжилгээний багийг Эрүүл мэндийн газрын нөхөн үржихүйн эрүүл мэнд, хүүхдийн тусламж хариуцсан мэргэжилтнүүд зохион байгуулалтаар ханган ажиллана.

б.Эрүүл мэндийн газраас үзлэг зохион байгуулах удирдамж, графикийг урьдчилан хүргүүлж, арга зүйгээр хангасан байна.

в.Нарийн мэргэжлийн үзлэгийн багт ажиллах эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг мэдээллээр хангах

г.Үзлэгийн багт ажиллах Эрүүл мэндийн газрын мэргэжилтнүүд нь сумдын эмнэлэг, эрүүл мэндийн төвийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, статистик мэдээ, мэдээлэлд дэмжлэгт хяналт хийж, ажлын байранд зөвлөн туслах

д.Нарийн мэргэжлийн эмч нар нь сум, өрхийн эмнэлэг, эрүүл мэндийн төвд үзлэг, шинжилгээ хийсэн тоон мэдээг өдөр тутамдаа багийн ахлагчдаа өгч, хамтарч ажиллах

е.Үзлэгийн багийн ахлагч нь тоон болон бичмэл тайлан, сумдын эрүүл мэнд хэрэгжүүлсэн ажлын илтгэх хуудсыг сумдад ажиллаж дууссанаас хойш 7 хоногийн дотор нэгтгэн бичиж, байгууллагын удирдлагуудад тайлагнах

8. Сумдад ажиллах багийн бүрэлдэхүүн:

Ахлагч: С.Дуламсүрэн, ЭМГ-ын НЭМХ-ийн өсвөр үе, нөхөн үржихүйн эрүүл мэнд, лабораторийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

Гишүүд: -Б.Ариунзаяат, ЭТХ-ийн хүүхдийн тусламж хариуцсан мэргэжилтэн

- С.Энхцэцэг, ЭТХ-ийн сувилахуйн тусламж хариуцсан мэргэжилтэн
- Б.Оюунчимэг, НЭМХ-ийн эрүүл мэндийн мэдээлэл сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн

Эмч нарын баг: Эх барих эмэгтэйчүүдийн эмч -1

- Хүүхдийн эмч – 1
- Дотрын эмч – 1
- Лаборант – 1 /хепатитийн В, С вирус илрүүлэх, БЗДХ илрүүлэх шинжилгээ хийх/
- ЭХО-гийн эмч – 1
- Зүрхний цахилгаан бичлэгийн сувилагч - 1
- Жолооч – 2

Хүлээгдэж буй үр дүн: Монгол улсын Засгийн газрын тогтоол, ерөнхий сайдын захирамж, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвөөс гаргасан зөвлөмж, Эрүүл мэндийн сайд, аймаг орон нутгийн бодлого, шийдвэр, Эрүүл мэндийн газрын даргын тушаалуудын хэрэгжилт сайжирч, алслагдсан, тусламж үйлчилгээнээс хоцрогдох малчид, тариаланчид, эрсдэл бүхий зорилтот насны хүн амыг нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, шинжилгээнд хамруулж, эмчлэн эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулсан байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 19-ны өдрийн 305 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

**ЯВУУЛЫН АМБУЛАТОРИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ АЖЛААР СУМДАД АЖИЛЛАХАД
 ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

№	Зардлын төрөл		Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт дүн	Санхүүжилтийн эх үүсвэр
1	Бензин шатахуун Пургон, 100-д 18л	1-р ээлж	187.6 л /АИ92 бензин/	1042 км	2100	393876	Монголын гэр бүлийн сайн сайхны нийгэмлэгийн салбар
		2-р ээлж	174.96 л /АИ92 бензин/	972 км	2100	367416	
2	Томилолт	Эмч 7*24 өдөр	хүн/өдөр	168	12000	2016000	Аймгийн Засаг даргын Тамгын газар
НИЙТ						2777292	
3	Үзлэг шинжилгээнд шаардагдах урвалж, оношлуур	ХДХВ/ДОХ	ш	700	2499	1749300	
		Тэмбүү илрүүлэх	ш	700	2450.55	1715385	
		Хепатитийн В вирус	ш	700	1900.6	1330420	
		Хепатитийн С вирус	ш	700	2550	1785000	
		Эмэгтэйчүүдийн үзлэгийн толь	ш	700	1000	700000	
		Наацын шинжилгээний урвалж будаг 500мл	багц	1	102000	102000	
		Тавиур шил 1*50	багц	10	5850	58500	
		Эсийн шинжилгээний бамбар 1*100	багц	5	39000	195000	
		Бээлий /1*50/	хайрцаг	20	40000	800000	
4	Бензин шатахуун Пургон, 100-д 18л	1-р ээлж	187.6 л /АИ92 бензин/	1042 км	2100	393876	
		2-р ээлж	174.96 л /АИ92 бензин/	972 км	2100	367416	
5	Томилолт	Жолооч 1*24	хүн/өдөр	24	12000	288000	
Нийт						9484897	
6	НҮЭМ-ийн сургалт, сурталчилгааны материал олшруулах		ш	5000	200	1000000	Эрүүл мэндийн газар
7	Томилолт	Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн 4*24 өдөр	хүн өдөр	96	12000	1152000	
8	Анонс, стикер	м2 /1.3*0.8/*2ш		2.08	11000	22880	
Нийт						2174880	
9	Нийт дүн			14437069	Аймгийн Засаг даргын Тамгын газар 9484897		
					МГБССН- 2777292		
					Эрүүл мэндийн газар - 2174880		